



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 59

Мандалговь

┌ Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Өндөршил сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 22,360,400 /хорин хоёр сая гурван зуун жаран мянга дөрвөн зуу/ төгрөгийн балансын үнэтэй, 14,596,372 /арван дөрвөн сая таван зуун ерэн зургаан мянга гурван зуун далан хоёр/ төгрөгийн элэгдэл бүхий 09-36 ДУА улсын дугаартай УАЗ Фургон маркын автомашиныг тус сумын Ерөнхий боловсролын сургуульд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Өндөршил сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Амгаланжаргал, Өндөршил сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Н.Дэлгэрсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 07-р сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

480219141